БАТЛАВ:

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

…… Ч.ГҮНЖДАГВА

ТАВАНТОЛГОЙ ХК

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

“ТАВАНТОЛГОЙ УУРХАЙН НҮҮРС АЧИЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР”

АГУУЛГА

НЭГ: ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ 3

1.1 Хийгдэх ажил 3

1.2 Инженерийн ажил 4

1.3 Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт 4

1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй 5

1.5 Нүүрс ачилтын үнэлгээ 5

1.6 Ажлын даалгаврын хавсралт 5

ХОЁР: ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА 6

2.1 Ерөнхий 6

2.2 Ажиллах хүч 6

2.3 Шалгарсан оролцогчид ажил эхлэх болон гүйцэтгэх үед тавигдах шаардлага 7

2.4 Техник, тоног төхөөрөмж, машин механизм: 7

2.5 Дэд бүтэц, барилга, байгууламж: 8

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ БУСАД ШААРДЛАГА 9

3.1 Гүйцэтгэгчийг үнэлэх үзүүлэлт 9

3.2 Бусад шаардлага 9

ДӨРӨВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ 10

ТАВАНТОЛГОЙ УУРХАЙН НҮҮРС АЧИЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, чиглэл, зааварчилгаа болон захиалагч талын мөрдөж буй байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт, дүрэм журам, заавар, нүүрсний овоолгод ачилт хийх паспорт, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой нүүрсний ордын "Тавантолгой" ХК-ийн уурхайн агуулахын талбайн нүүрсний овоолгоос худалдан авагч талын тээврийн хэрэгсэлд нүүрс ачилтын ажил хийж гүйцэтгэнэ.

НЭГ: ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

1.1 Хийгдэх ажил

1.1.1. Нүүрсний агуулахын талбай дахь овоолгоос нүүрс тээврийн хэрэгсэлд батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу оновчтой техник, тоног төхөөрөмжөөр нүүрс ачна;

1.1.2. Нүүрс тээврийн хэрэгслийн төрөл, экспортын чиглэлээс хамааран зөвшөөрөгдсөн тонн жинд тааруулан ачилтыг бүрэн хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Авто замаар тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэлд тухайн экспортын чиглэлээс хамааран зөвшөөрөгдсөн тонн жинд тааруулан ачна;

1.1.3. Авто замын тээврийн хэрэгсэлд ачих нүүрсний ширхэглэлийн зөвшөөрөгдөх хэмжээ 400x400x400 мм-ээс бага байна. Шаардлагатай үед ачигдах нүүрсний ширхэглэлийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байх тохиолдолд тухайн нүүрсийг буталж, ширхэглэлийн хэмжээг тааруулна;

1.1.4. Авто замын тээврийн хэрэгсэлд ачилт хийх үед авто зам руу хаягдсан нүүрсийг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Уг ажлыг хийж гүйцэтгээгүйгээс үүдэн гарах үр дагаврыг бүрэн хариуцна;

1.1.5. Нүүрс ачилтын эрчим нэмэгдэх, их ачаалалтай үед нэгэн зэрэг ачилт хийх техникийн нөөцтэй байна;

1.1.6. Захиалагчаас гаргасан ажлын төлөвлөгөө, ачилтын паспорт, аюулгүй ажиллагааны журам, зааварчилгааг нүүрсний агуулахын болон бусад зам талбайд мөрдөж ажиллана. Нүүрсний 8-10 м өндөртэй овоолгоос ачилт хийх хүчин чадалтай утгуурт ачигчийг ачих, шаардлагатай тохиолдолд гүйцэлт өндөр үүсгэсэн овоолгоос ачилт хийх үед овоолгын өндрийг бульдозероор намсгаж ачилт гүйцэтгэнэ;

1.1.7. Нүүрсийг ачилтын явцад бохирдуулан худалдан авагч талд хохирол гаргасан тохиолдолд захиалагч акт үйлдэж, тухайн жилийн хөрс хуулалтын илтгэлцүүрийн өссөн дүнгээр тооцон хөрсний хэмжээг гаргаж, олборлолтын өртгөөр тооцон тухайн сарын гүйцэтгэсэн ажлын төлбөрөөс хасаж тооцно;

1.1.8. Нүүрсний овоолгоос дээжлэлт хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг ажиллуулна;

1.1.9. Нүүрсний овоолгод халалт, уугилт гарсан тохиолдолд шатсан нүүрсийг тусгаарлах, шилжүүлэх арга хэмжээ авна;

1.1.10. Ачилтын бусад орсон бүх зам, талбайн тоосыг дарах буюу усалах ажлыг хийж гүйцэтгэнэ. Нүүрсний агуулахын зам, нүүрсний овоолгын ул, ачилтын талбай, нүүрсний овоолго хоорондын зам, хяналтын автожин, оролт, гаралтын автожингийн зам, экспортын тээврийн машины паркийн талбай болон бусад бүх зам орно. Мөн эдгээр бүх замыг автогрейдер ашиглан засах тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэнэ;

1.1.11. Ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ачилт хийж буй хэсгийн тээврийн зам, ажлын бүс, овоолго бүрд, ажлын талбайн гэрэлтүүлгийг хангалттай хэмжээнд байрлуулна;

1.1.12. Нүүрсний овоолгод овор хэтэрсэн нүүрс гарах тохиолдолд буталж, жижиглэх арга хэмжээг авч ажиллана. Тус арга хэмжээг авч ажиллаагүйгээс шалтгаалсан өмчийн эвдрэл, осол, хохирлыг төлж барагдуулна;

1.1.13. Нүүрсний зах зээлийн нөхцөл байдлаас хамааралтайгаар нүүрс ачилтын эрчим буурч зарим техникүүдийг ажлаар хангах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч нь аливаа торгууль болон төлбөрийн хариуцлага хүлээхгүй;

1.1.14. Ачилт, буулгалт хийж гүйцэтгэх ачигч техникийн утгуурт жин хэмжүүр суурилуулан чингэлэгт ачигдах нүүрсний хэмжээг тодорхойлох боломжтой байх бөгөөд ачигдсан тээврийн хэрэгслийг автожингээр жинлэхэд зөвшөөрөгдсөн жингийн зөрүү үүсэхгүй байх;

1.1.15. Захиалагчийн саналаар захиалагчийн хэрэгжүүлж буй бусад төслийн талбайд гэрээнд заах үнийн дүнгээр төлбөрийг тооцож шилжүүлэн ажиллуулж болно.

1.2 Инженерийн ажил

1.2.1. Захиалагчийн шаардлагын дагуу гэрээний хавсралтад заасан төлөвлөгөөний тухайн сард гүйцэтгэх ажлын 0.5 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Хэрэв захиалагчаас гүйцэтгүүлэх бүтээлийн бус инженерийн ажил байхгүй нөхцөлд улирал тутамд хуримтлагдсан дүнгээр тооцож, гүйцэтгэлийн төлбөрөөс хасаж тооцно;

1.2.2. Зам талбайг засах, шинээр тавих шаардлагаар захиалагчийн хамгаалалтын хашааг шилжүүлэх шаардлага үүссэн нөхцөлд гүйцэтгэгч өөрийн зардлаар шилжүүлэн захиалагчид хүлээлгэж өгнө;

1.2.3. Уурхайн гаднах буюу маршрутын замыг захиалагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу зам арчилгааны ажил хийж гүйцэтгэнэ.

1.3 Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт

1.3.1. Гүйцэтгэгч нь байгаль орчин, усны бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт ажил гүйцэтгэгчийн хүлээх үүргийг хуваарийн дагуу биелүүлж, биелэлтийг захиалагчид улирал бүр тайлагнана;

1.3.2. Нүүрс ачилтын үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг Монгол улсын хууль, журам, стандарт болон захиалагчийн дотоод журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, аюултай хог хаягдлыг устгах буюу саармагжуулах, хог хаягдлын стандарт байгууламжийг барих, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж гэрээт хугацаанд буюу жил бүр төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана;

1.3.3. Үйл ажиллагааны явцад эвдэрсэн, доройтсон, бохирдсон газар болон хог хаягдлын түр цогц техникийн нөхөн сэргээлт хийн бохирдлыг арилгаж, ажил дуусгавар болоход захиалагчид хүлээлгэж өгнө;

1.3.4. Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцөлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна;

1.3.5. Гэрээний дагуу ажил гүйцэтгэх явцад өртсөн, ашигласан бүхий л газар, талбайд нөхөн сэргээлт хийж захиалагчид хүлээлгэж өгнө;

1.3.6. Байгаль орчны чиглэлээр хийгдэх аливаа ажилд техник тоног төхөөрөмжийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ;

1.3.7. Монгол улсад мөрдөгдөж буй Байгаль орчны багц хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журмыг мөрдөх, MNS 5914:2008, MNS 5915:2008, MNS 5917:2008 стандартын дагуу эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, ургамалжуулалтыг хийнэ;

1.3.8. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн, тусгагдсан ажлуудыг дэмжиж ажиллах.

1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

1.4.1. Нүүрс ачилтыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана;

1.4.2. Нүүрс ачилтын ажилд зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна;

1.4.3. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, усны бодлогын /Цаашид ХАБЭА, БОУБ гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй;

1.4.4. ХАБЭА, БОУБ-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй;

1.4.5. ХАБЭА, БОУБ-той холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан болон цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд талууд оролцож тэмдэглэл үйлдэн тухайн ажлыг зогсооно;

1.4.6. Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцөлийг бүх ажлын байруудад арилгасны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засаж залруулах арга хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБ-ын хэсэгт харгалзах оноог бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сарын гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБЭА, БОУБ хэсэгт харгалзах оноог бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна;

1.4.7. ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг жил болон сараар дүгнэх, уг дүгнэлтийг сар бүрийн төлбөртэй хэрхэн уялдуулж тооцоолох Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлтийг гэрээнд нарийвчлан тусгана.

1.5 Нүүрс ачилтын үнэлгээ

1.5.1. Уурхайн агуулах дахь нүүрсний овоолгоос нүүрс тээврийн хэрэгсэлд нүүрс ачих ажлын нэгж үнэлгээг 1,500 (нэг мянга таван зуун төгрөг) төг/тонн–оор тооцно.

1.5.2. Захиалагч нь нүүрс ачилтын ажлын гүйцэтгэлийн төлбөрийг гүйцэтгэгч талд төгрөгөөр тооцон төлнө.

1.6 Ажлын даалгаврын хавсралт

1.6.1. Хавсралт хүснэгтүүд:

- Хүснэгт 1. Ажиллах хүний нөөцийн мэдээлэл

- Хүснэгт 2. Техник, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
- Хүснэгт 3. Нүүрс ачилтын хуваарь
- Хүснэгт 4. Техник, тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

1.6.2. Хавсралт зургууд:

- Зураг 1. Нүүрс ачилтын талбайн зураг
- Зураг 2, 3. Нүүрсний овоолгод ачилт хийх паспорт

ХОЁР: ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 Ерөнхий

2.1.3. Гүйцэтгэгч нь 1-аас доошгүй жил уул уурхайн салбарт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил, нүүрс ачилтын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх;

2.2 Ажиллах хүч

2.2.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн багийн гишүүдийг бүрдүүлсэн байх бөгөөд дараах ажилтнуудыг ажиллуулна. Үүнд:

Хүснэгт 1 Ажиллах хүний нөөцийн мэдээлэл

№	Албан тушаал	Мэргэжил	Тоо	Туршлага
Тендерт үнэлэх ажилтнууд				
1	Ээлжийн мастер /талбайн зохицуулагч/	Уул уурхайн инженер мэргэжилтэй	2	Сүүлийн нэг жил нүүрс олборлолт, хөрс хуулалт, нүүрсний ачилт хийж байсан туршлагатай
2	Утгуурт ачигчийн оператор	Мэргэжил сургалтын гэрчилгээ	4	Сүүлийн нэг жил нүүрс олборлолт, хөрс хуулалт, нүүрсний ачилт хийж байсан туршлагатай
Шалгарсан оролцогч нь ажил эхлэх үед дараах ажилтнуудыг ажиллуулна				
3	Төслийн менежер	Мэргэжил харгалзахгүй	1	Сүүлийн нэг жил нүүрс олборлолт, хөрс хуулалт, нүүрсний ачилт хийж байсан туршлагатай
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх сертификат	2	Сүүлийн нэг жил нүүрс олборлолт, хөрс хуулалт, нүүрсний ачилт хийж байсан туршлагатай
5	Засварын механик	Механик	2	-
6	Диспетчер	Мэргэжил харгалзахгүй	2	Сүүлийн нэг жил нүүрс олборлолт, хөрс хуулалт, нүүрсний ачилт хийж байсан туршлагатай

Тайлбар:

- Уул уурхайн инженер мэргэжилтэй гэдэг нь уул уурхайн ашиглалтын технологи, уул уурхайн маркшейдер, уул уурхайн менежмент, ашигт малтмалын баяжуулагч инженер, эсхүл геологи мэргэжилтэй байна.
- Байгаль орчны мэргэжилтэй гэдэг нь байгаль орчны хяналт үнэлгээ, хүрээлэн буй орчны инженер, эсхүл экологич байна.
- Механик гэдэг нь авто инженер, механик инженер, эсхүл тус чиглэлээр мэргэжил, үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалт төгссөн үнэмлэхтэй байна.

- Мэргэжил сургалтын гэрчилгээ гэдэг нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, эсхүл политехник коллежийн сургалтад хамрагдсан диплом, гэрчилгээ, сертификат, эсхүл үнэмлэх.
- Инженер техникийн ажилчид нь сүүлийн 3 сар тухай компанид тасралтгүй ажиллаж, нийгмийн даатгал төлсөн байх.

2.3 Шалгарсан оролцогчид ажил эхлэх болон гүйцэтгэх үед тавигдах шаардлага

2.3.1. Нүүрс ачилтын ажлыг гүйцэтгэх ажилтнууд нь ажил үүргээ аюул, осолгүй, технологи, горимын дагуу хэвийн явуулах машин, тоног төхөөрөмж, ажлын багаж, хувцас, хамгаалах хэрэглэлээр бүрэн хангагдсан байна;

2.3.2. Техникийн бэлэн байдлыг 85-ээс дээш хувьтай байлгаж ажиллана;

2.3.3. Радио холбоогоор тоноглогдсон байх бөгөөд "Тавантолгой" ХК-ийн радио долгионы давтамжтай ижил байна;

2.3.4. Захиалагчийн шаардсан нүүрс ачилтад тохирсон техник, тоног төхөөрөмж, операторууд, ачилтын нөөц техникүүдийг бэлэн байлгах үүрэгтэй;

2.3.5. Нүүрс тээврийн хэрэгсэлд ачилт хийх явцад гүйцэтгэгч талын техник болон ажилтны буруутай үйл ажиллагаанаас гарсан хохирлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна;

2.3.6. Захиалагчийн шаардлагын дагуу нүүрсний овоолгын саравчилсан хэсгийг аюулгүй болгох болон өндөр ханыг намсгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ;

2.3.7. Шаардлагатай тохиолдолд уурхайн бусад хэсгийн нүүрсний овоолгуудаас нүүрс ачилтын ажлыг захиалагч урьдчилан мэдэгдсэний дагуу хийж гүйцэтгэх боломжтой байна;

2.3.8. Техникийн засвар үйлчилгээ хариуцсан механикийн баг бүрэлдэхүүнтэй байх;

2.3.9. Шалгарсан оролцогч нь ажил эхлэхэд осол аваарын үед эмнэлгийн тусламж үзүүлэх эмч, эмнэлгийн ажилтан, яаралтай тусламжийн нэгжтэй байна;

2.3.10. Оролцогч нь ажил гүйцэтгэх хугацаанд ХАБЭА, мэргэжлийн болон бусад үйл ажиллагаанд шаардлагатай сургалтыг бүрэн хариуцах бөгөөд сургалтын бүртгэл тайланг Захиалагчийн сургалт хариуцсан нэгжид хүргүүлж байна.

2.4 Техник, тоног төхөөрөмж, машин механизм:

2.4.1. Гүйцэтгэгч нь Үйл ажиллагааны хуваарь /Хүснэгт 3/-т заасан нүүрс ачилтын ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна;

2.4.2. Сард 625.0 мян.тн нүүрс ачилтын ажил гүйцэтгэх, жилд 7.5 сая тн нүүрс ачилтын ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хослол бэлэн байлгаж ажиллана;

Хүснэгт 2. Техник, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

А. Үндсэн техникүүд
Нүүрс ачилтын ажил гүйцэтгэх техникүүд нь дараах хүчин чадалтай байна. • **10.1 м^3**-ээс багагүй утгуурын багтаамжтай утгуурт ачигч **1-оос** багагүй, (өөрийн эзэмшлийн байна) • **7 м^3** болон түүнээс дээш утгуурын багтаамжтай утгуурт ачигч **2-өөс** багагүй, (өөрийн эзэмшлийн байна) **Тайлбар:** Утгуурын багтаамжийг техник үйлдвэрлэгчээс заасан техникийн дээд, доод хязгаарын үзүүлэлтээр тооцно. м^3 гэдэг нь Олон улсын систем (SI) дэх 1000 литр нь 1 метр куб (cubic metre) байна.

B. Туслах техник, тоног төхөөрөмжүүд
Шалгарсан оролцогч нь дараах туслах техник, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулна. • 3-5 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч 1-ээс багагүй, (нүүрс тээврийн хэрэгсэлд шаардлагатай үед нэмэлт, хасалт хийх, нүүрсний овоолгод халалт уугилт гарсан үед тараах, овоолох, инженерийн ажил, хучлагын байрны цэвэрлэгээний ажил гүйцэтгэх гэх мэт) • Нүүрс тээврийн хэрэгслийн тэвшнээс нүүрсний нэмэлт, хасалт хийх зориулалттай 3-5 м³ базагч шанагатай /Clamshell Bucket/ экскаватор 1-ээс багагүй. • 10-20 тонны даацтай 1-оос багагүй усалгааны машинуудыг ажиллуулна. • 40 тонноос дээш даацтай 1-ээс багагүй автосамосвал ажиллуулна. /нэмэлт хасалтын талбай руу нүүрс зөөх зориулалтай/
• Шаардлагатай үед бүхэллэг том нүүрсийг бутлах зориулалтын тоноглолтой техникийг ажиллуулна. • Нүүрс ачилт болон нэмэлт хасалтад ажиллах техникүүдэд Захиалагчийн нүүрс ачилтын программ суулгаж, мэдээлэл, дата өгөгдөл дамжуулах зориулалттай мобайл компьютер суурьлуулсан байх. Техникийн үзүүлэлт: 24Вт ажилладаг, техникийн кабин суурьлуулах боломжтой суурьтай байх, 2.4 Gzh болон түүнээс багагүй external Wifi omni сүлжээний антентай байх. **Тайлбар:** Тонн гэдэг нь Олон улсын систем (SI) дэх 1000 кг нь 1 тонн (metric ton) байна. м³ гэдэг нь Олон улсын систем (SI) дэх 1000 литр нь 1 метр куб (cubic metre) байна. Даац гэдэг нь цэвэр ачих жинг хэлнэ. (ачаагүй жинг оруулж тооцохгүй).
Хүснэгт 2-ын А, В хэсэгт тусгагдсан техникүүдийг Захиалагчаас төлөвлөсөн болон шаардсан хугацаанд ажиллуулаагүй тохиолдолд гарсан хохирлыг төлүүлнэ.
C. Бусад туслах техникүүд Шалгарсан оролцогч нь доорх техникүүдийг ажил эхлэх болон гүйцэтгэх үед уурхайд захиалагчаас шаардсан тоо хэмжээгээр бэлэн байлгана.
• Гэрэлтүүлэгч цамхаг • Хог, хаягдлыг тооворлох машин • Түлшний машин

2.4.3. Нүүрс ачилтын төлөвлөгөө, зураг төсөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн нүүрс ачилтын ажил хийх хангалттай хүчин чадалтай, иж бүрэн үндсэн тоног төхөөрөмжүүдтэй байна;

2.4.4. Шаардлагатай тохиолдолд Захиалагчаас гаргасан төлөвлөгөөний дагуу нүүрс ачилтын ажилд ажиллах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх болон бууруулах боломжтой байна;

2.4.5. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн загвар, тоо, бүтээл, үйлдвэрлэсэн огноо, бусад шаардлагатай мэдээллийг Хүснэгт 4-ийн дагуу бөглөн жагсаалтыг ирүүлнэ.

2.5 Дэд бүтэц, барилга, байгууламж:

2.5.1. Ажилчид болон тоног төхөөрөмжүүдийг Радио холбоогоор бүрэн тоноглосон байна. Захиалагчийн радио долгионы давтамжтай ижил байх;

2.5.2. Нүүрс ачилтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай дараах барилга, байгууламжуудыг ажил эхлэх үед ашиглалтад оруулж, шийдвэрлэж ажиллана. Үүнд:

- Ариун цэврийн шаардлага хангасан кемп буюу ажилчдын сууц, амрах байр, мөн хоол хүнсний зориулалтын дагуу хадгалах агуулах
- Стандартын дагуу баригдсан ахуйн хог хаягдлын цэг
- Эрчим хүчний эх үүсвэр (нөөцийн генераторууд)
- Засварын байр, түүнийг дагалдах тоноглол, байгууламж
- Оффисын байр, сургалтын танхим
- Стандартын ашигласан тос төвлөрүүлэх байгууламж
- Хог хаягдлыг шатаах зориулалтын төхөөрөмж бүхий хоргүйжүүлэх талбай
- Бохирдсон хөрсийг төвлөрүүлэн биологийн аргаар саармагжуулах талбай

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ БУСАД ШААРДЛАГА

3.1 Гүйцэтгэгчийг үнэлэх үзүүлэлт

3.1.1. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд дараах байдлаар үнэлж KPI оноо өгнө;
- Гэрээний үүргийн хэрэгжилт - 10 оноо,
- Үйлдвэрлэл ачилт - 65 оноо,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй - 20 оноо,
- Байгаль орчин - 5 оноо

3.1.2. KPI оноо, үнэлгээний үзүүлэлтийг гэрээ байгуулах үед нарийвчлан дэлгэрэнгүй тусгана;

3.1.3. Гүйцэтгэгчийн тухайн сард гүйцэтгэсэн ажлын KPI оноо 90 оноонoос багаар үнэлэгдсэн тохиолдолд тухайн сарын төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгээс багаар үнэлэгдсэн оноо тутамд дараах байдлаар харгалзах хувиар Гүйцэтгэгчид төлөх тухайн сарын гүйцэтгэлийн төлбөрөөс хасаж тооцно;
- 89.9-80 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.01%-иар,
- 79.9-70 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.02%-иар,
- 69.9-60 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.03%-иар,
- 59.9 буюу түүнээс доош оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.05%-иар тус тус тооцно.

3.1.4. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэлийн хуралдаан бүрээр хугацаат үүрэг даалгаврыг заасан хугацаанд хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлээгүй тохиолдолд KPI онооноос хасна;

3.1.5. Гэрээний хугацаанд 3 удаа /сар/ KPI оноо 70 хувиас доош орсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг шууд цуцлах үндэслэл болно;

3.1.6. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэл дүгнэх хуралд ажлын тайланг танилцуулах бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажлын нэгж өртөг, түлш зарцуулалт, тоног төхөөрөмжүүдийн гүйцэтгэлүүдийг холбогдох нотлох баримтуудын хамт тайланд багтаасан байх ба дараа сарын 05-ны өдрөөс өмнө Захиалагчид ирүүлсэн байна. Тайлангийн чанар, бэлтгэсэн байдал, мэдээлэл зэрэг нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй тохиолдолд тайланг буцааж, гүйцэтгэл дүгнэх хурлыг хойшлуулж болно;

3.1.7. Захиалагч гэрээний дүгнэлт танилцуулах, Гүйцэтгэгчийн тайлантай танилцах хурлыг төслийн удирдлагын багийн дарга тухайн сарын 10-ны дотор товлон зарлаж хуралдуулна.

3.2 Бусад шаардлага

3.2.1. Нүүрс ачилтын ажил гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас

тушаал шийдвэр гаргуулах, газар ус болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах зэрэг асуудлыг Гүйцэтгэгч тал өөрөө хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал болон бусад талууд хариуцахгүй;

3.2.2. Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт заасан техник хэрэгсэл, машин механизм болон дэд бүтцийн барилга байгууламжийг заасан хэмжээ, үзүүлэлтийн дагуу уурхайд бэлэн байлгах бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүр Захиалагчид хүргүүлнэ;

3.2.3. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай түлш, сэлбэг хэрэгслийн 14-өөс багагүй хоногийн нөөцтэй байх бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүрийн 15-ны өдөр Захиалагчид хүргүүлнэ;

3.2.4. Уурхайн бусад хэсэгт ажиллаж буй гүйцэтгэгч гэрээт гүйцэтгэгч компанитай үл маргах, эвлэрэн шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллах;

3.2.5. Нүүрсний овоолгын болон технологийн замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах;

3.2.6. Захиалагч нь 7-оос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний дүнд ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд сул зогсолт хийлгэж болно. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй;

3.2.7. Захиалагчаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжилтийг ханган ажиллах ба тавьсан шаардлага биелүүлээгүй тохиолдолд хариуцаж буй албан тушаалтныг төслийн талбайд нэвтрүүлэхгүй;

3.2.8. Давагдашгүй хүчин зүйл (УИХ, Засгийн газрын шийдвэр, Хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм, бусад багцын ХАБ-ын зөрчил)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

ДӨРӨВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

Хүснэгт 3. Нүүрс ачилтын хуваарь

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Инженерийн ажил
1-р жил	тн	7,500,000.0	37,500.0
2-р жил	тн	7,500,000.0	37,500.0
Нийт	**тн**	**15,000,000.0**	**75,000.0**

Сар бүр гүйцэтгэх нүүрс ачилтын хэмжээг тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, нүүрсний ачилт, борлуулалт, экспортоос хамааран захиалагч өөрчилж болно.

Захиалагч нь шаардлагатай тохиолдолд нүүрс ачилтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эрхтэй. Үүнтэй холбоотой сул зогсолт хийх тохиолдолд захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

Хүснэгт 4. Техник, тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

д.д	Тоног төхөөрөмжийн нэр		Хүчин чадал, багтаамж		Сарын бүтээл, мян.м^3 (зөвхөн утгуурт ачигч)	Үйлдвэрлэсэн огноо	Түлш зарцуулалт, л/мото.цаг	Ажиллах байршил, нүүрс ачилт/нэмэлт хасалт/бусад ажил	Өмчлөлийн хэлбэр	Тайлбар
	Төрөл	Загвар	Нэгж	Хэмжээ						
	Утгуурт ачигч									
	Утгуурт ачигч (Clamshell bucket)									
	Усны машин									
	Автогрейдер									
	Бусад									

Тайлбар: Техник, тоног төхөөрөмжүүдийн техникийн бэлэн байдлыг 85-ээс дээш хувьтай байлгана.

Зураг 1. Нүүрс ачилтын талбайн зураг



Зураг 2. Нүүрсний овоолгоос ачилт хийх паспорт

1:200

CAT 992K,CAT 988, WA 800, Kavasaki 135 дугуйт ачигчуудын нүүрсний овоолгод ачилт хийх паспорт



Зураг 3. Нүүрсний овоолгоос ачилт хийх паспорт

М 1:200

LIEBHERR 580, HYUNDAI 780, LIUGONG, ZL50CN дугуйт ачигчуудын нүүрсний овоолгод ачилт хийх паспорт



ХЯНАСАН:

БОРЛУУЛАЛТ, ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ГАНБАТ

БОЛОВСРУУЛСАН:

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН АХЛАХ ИНЖЕНЕР Ө.ГАН-ОД